

ОРЧУУЛГЫН НИЙТЛЭГ БА ОРЧУУЛГЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ

Б.Удвал⁸⁵

Abstract: *Equivalence can be said to be the central issue in translation. The House's TQA model is more appropriate for the literature translation than other models. This paper demonstrates the revised 1997, model of translation quality assessment by displaying an analysis of result of an original text and its overt translation. Universals of translation are linguistic features also there are number of features considered to translation method. These features concern simplification, explication, normalization, distinctive distribution of lexical items. And also we are trying to look for opportunities to identify the cultural translation principle by contrastive analyses of English translation and source text.*

Түлхүүр үг: *Орчуулгын нийтлэг, хураах, дэлгэрүүлэх, Жулиан Хаус, орчуулгын чанар, хэв шинж*

1.1 Хаусын дэвшүүлсэн орчуулгын чанарын үнэлгээний загвар болон ил ба далд орчуулгын хэв шинж.

Германы хэл шинжлэлч, эрдэмтэн Жулиан Хаус анх 1977 онд аливаа орчуулга үүргийн хувьд бүрэн дүйцэлтэй байхын тулд эх бичвэр, орчуулгын бичвэр хоёр утга зүйн (semantic) болон хэрэглээний (pragmatic) дүйцэлийг хангаж байх ёстой гэдэг асуудлыг дэвшүүлсэн. Тэрээр эх бичвэрийн нөхцөлт цар хүрээг (situational dimension) тодорхойлсноор түүний үүргийг тодорхойлж болно гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, эх бичвэр бүр өөр өөрийн онцлог нөхцөл байдал, хэв шинжтэй бичигддэг харин орчуулагч үүнийг зөв тодорхойлж орчуулгаа хийх хэрэгтэй. Хаус хэдийгээр орчуулгын бичвэр эх бичвэртэйгээ бүрэн дүйцэлтэй байх боломжгүй ч нөхцөлт цар хүрээ буюу хам утгаар нь орчуулж орчуулгын дүйцлийг хангах боломжтой гэж тайлбарлажээ.

Үүний үндсэн дээр тэр орчуулгын хоёр төрлийн хэв шинжийг (typology) тодорхойлсон байна. Эдгээр нь ил орчуулга (overt translation) болон далд орчуулга (covert translation) болно.

Ил орчуулга нь (overt translation) орчуулгын бүтээл гэдэг нь уншигчдад илэрхий бөгөөд эх бичвэрийн хэл, соёлтой бүрэн холбоотой байдаг. Өөрөөр хэлбэл, уншигч бүтээлийг уншиж байхдаа орчуулгаар дамжуулан харь хэлний соёлтой танилцаж байдаг тул орчуулагч эх бичвэрт байгаа соёлын ялгааг хэвээр нь хадгалан орчуулна.

⁸⁵ МУИС-ийн Завхан сургуулийн багш, докторант

Энэ хэв шинжийн орчуулга нь нийгмийн тодорхой нэг бүлэгт биш бүхэлд нь чиглэсэн байдаг бөгөөд Хаус ил орчуулгын хэв шинжийг дотор нь хоёр ангилсан байна. Үүнд:

Түүхэн бичвэрийн орчуулга: Английн Брафордод Уинсон Чөрчилийн дэлхийн 2-р дайны тухай мэдэгдэл

Тодорхой цаг хугацаанд хамаарахгүй бичвэрийн орчуулга: Урлаг уран сайхны бүтээлүүд, ёс суртахууны сургаалууд зэрэг эх бичвэрийн соёлтой салшгүй холбоотой бүтээлүүд багтдаг бөгөөд энэ хоёр хоёулаа бүтээлч сэтгэлгээний хэв шинжийг агуулдаг.⁸⁶

Ил орчуулгын хэв шинжээр орчуулагч уншигчдыг харь соёлд хөтлөх үүрэг хүлээдэг.

Далд орчуулга нь нийгмийн аль нэг тодорхой бүлэгт чиглэсэн, эх бичвэрийн хэлний соёлтой харилцан хамааралгүй, энэ хэв шинжийн орчуулга нь орчуулж буй хэлний соёлд тохируулан орчуулсан байдаг. Орчуулгын бичвэрийн хүлээн авагчид буюу уншигчид нь эх бичвэрийн уншигчидтай ижил түвшний хүмүүс байдаг.

Хаус 1977 онд орчуулгын энэ хэв шинжийг шинжлэх ухааны текст (математикийн сурах бичиг), жуулчны гарын авлага (Ньюрембергийн аялалын эмхтгэл), эдийн засгийн чиглэлийн бичвэр (ОУ-ын хөрөнгө оруулалттай компанийн ерөнхийлөгчийн хувьцаа эзэмшигчиддээ илгээсэн захидал), судалгааны өгүүлэл (Хүн судлалын судалгааны ажлын үр дүнгийн тухай өгүүлэл) зэрэг жишээ баримтуудаар тодруулан үзүүлсэн байдаг. Эдгээр жишээнээс харахад далд орчуулгад нь хэл нийгмийн онцлог, соёлын ялгаа огт байхгүй.

Тайваний орчуулга судлаач Ян Цу Ен орчуулгын энэ хоёр хэв шинжийг орчуулгын стратеги буюу арга барил гэж үзээд эдгээр арга барил стратеги нь орчуулагчид эх бичвэрийг орчуулж буй хэлэнд аль болох бүрэн дүйцэлтэй төгс буулгах боломж олгох бөгөөд энэ хоёр стратегийг орчуулагч орчуулга хийх явцдаа хамтад нь хоёуланг нь хэрэглэж болно гэж бичсэн байдаг.⁸⁷

Хаус эх бичвэр, орчуулга хоёрыг утгат хэсгүүдээр кодлон харилцан тохируулж, орчуулгыг буцаан эх бичвэрийн хэл рүү орчуулж үзсэний дараа дамжуулалтыг тодорхой хэмжүүрүүдээр үнэлэх загварыг Халлидейн бүтэц үүргийн онол, прагматикийн зарчим, Прагийн хэлшинжлэлийн дэгийн судлаачдын гаргасан бүртгэн жагсаах онол, найруулга зүй, хэл-ярианы шинжилгээний (discourse analysis) онолууд дээр үндэслэн зохиожээ.

⁸⁶ House, 2014b, p. 55

⁸⁷ <http://ir.lib.cyut.edu.tw:8080>

1.2 Жулиан Хаусын онол, зарчмын дагуу орчуулгын бүтээлд хийсэн шинжилгээ

2009 онд англи хэлнээ хөрвүүлэгдсэн С.Эрдэнийн “Өвгөн шувуу” өгүүллэгийн англи орчуулгад дээрх онол зарчмын дагуу орчуулгын чанарын шинжилгээ хийж утгат хэсэг бүрээр нь кодлон задалж эх бичвэртэй тулгаж, англи орчуулгыг буцааж эх хэлрүү нь хөрвүүлсэн.

Орчуулгын дүйцэл Хаусын тодорхойлсон хэмжүүрүүдийн түвшинд дараах байдлаар бүртгэгдсэн⁸⁸. (Эхний 29 утгат хэсгийг түүвэрлэн оруулав)

Үзүүлэлтүүд	Дүйцэл
ЗОХИОЛЫН ХҮРЭЭ (FIELD)	29 –н утгат хэсэг бүгд энэ үзүүлэлтийг хангаж байсан.
ЗОХИОГЧИЙН ЗОРЬСОН САНАА (TENOR)	29 –н утгат хэсгээс 4 утгат хэсэг дээр энэ үзүүлэлтийг хангаж чадаагүй.
АРГА БАРИЛ (MODE)	29 –н утгат хэсгээс мөн 4 утгат хэсэг дээр энэ үзүүлэлтийг хангаж чадаагүй

Энэ орчуулга нь тодорхой цаг хугацааны хамааралгүй, нийгмийн тодорхой нэг бүлэгт чиглээгүй, монгол хэл, соёлтой салшгүй холбоотой, уран сайхны төрөлд хамаарах ил /overt/ орчуулга юм. Иймд орчуулагч англи хэлт уншигчдыг эх бичвэрт илэрч байгаа монгол ахуй, монгол сэтгэлгээний соёлд хөтлөх үүрэгтэй.

Хаус энэ зарчим загвараараа англи хэлнээс герман хэл рүү орчуулсан хүүхдийн зохиолын ил /overt/ орчуулгад шинжилгээ хийж үзүүлсэн байдаг. Харин энэ зохиол нь бага насны хүүхдэд зориулсан хялбархан, соёлын ойлголт бага, богино өгүүллэг юм. Өвгөн шувуу өгүүллэгийн орчуулгад үргэлжлүүлэн шинжилгээ хийж өгүүллэгийг бүхэлд нь утгат хэсэг бүрээр нь кодлон задалж өгөгдсөн үзүүлэлтүүдийн дагуу задлан орчуулгын чанарт шинжилгээ хийсэн. Эндээс харахад тууж, роман зэрэг өгүүллэгээс том хэмжээтэй зохиолуудын орчуулгад Хаусын загвараар үнэлгээ хийхэд редакторын зүгээс нэлээд нүсэр ажил болох боловч зориод хийвэл утга зүйн (semantic) болон хэрэглээний (pragmatic) дүйцэл хангасан бүрэн дүйцэл бүхий орчуулга гарах боломжтой юм.

Хаусын тодорхойлсон орчуулгын хоёр гол хэв шинжээр орчуулгыг тодорхойлох нь хялбар тул энэ хоёр хэв шинжийн зарчмын дагуу орчуулгын чанарыг үнэлэхэд бас их боломжтой болох нь судалгааны явцад харагдаж байна.

2.1 Орчуулгын нийтлэг

Бейкерийн тодорхойлсноор орчуулгын нийтлэг гэдэг нь ихэнхдээ орчуулгын бичвэрт түлхүү илэрдэг хэлшинжлэлийн онцлог чанар юм. Орчуулгын нийтлэг гэж юу болох, түүний онцлог чанарууд, тэдгээрийг орчуулах үйл ажиллагаанд хэрхэн тусгасан талаар судлаачид дараах түгээмэл онцлогуудыг дурдсан байна.

⁸⁸ Орчуулга зүй № 06.2018 хуудас 76

Хураах (нэг санааг давтахаас зайлсхийх)

Дэлгэрүүлэх (эх бичвэрт байхгүй үг, өгүүлбэр нэмэх)

Тохируулах (Орчуулж буй хэлний онцлогт тохируулан хэлзүйн болон, тэмдэгтийн хувиргал хийх)

Хураах ба нэг санааг давтахаас зайлсхийх. (Simplification)

Блам Кулка, Левинстон нар үгийн сангийн хураалтыг үгийн тоог багасгах үйл ажиллагаа гэж тодорхойлсон байдаг. Еврей хэлнээс англи хэл рүү орчуулсан орчуулгад хийсэн шинжилгээ мөн өөр бусад хэлнүүдийн хооронд хийсэн шинжилгээнд үндэслэн Дагут (1971), Рабин (1958), Вондерли (1968), нар үгийн сангийн хураах зарчим нь орчуулагчийн эх хэлний чадамжаас хамааралтайгаар б зарчим стратегийн дагуу явагддаг гэж тодорхойлсон байдаг юм.

Эдгээр аргууд нь:

Орчуулж буй хэлнээс шууд дүйцэлтэй үг байхгүй бол ерөнхий нэр томъёог хэрэглэх.

Эх бичвэр дээрх ойлголтыг багцаалах

Түгээмэл хэрэглэгддэг ойролцоо утгатай үг ашиглах.

Эх бичвэрийн хэлний үгийн бүх үүргийг орчуулгын хэлэнд дүйцүүлэн хувиргах

Шашны үг хэллэг, соёлын онцлогтой үг хэллэг, техник технологийн нэр томъёо зэрэг нийтлэг бус үгээр илэрхийлсэн ойлголтуудыг шилжсэн утгатай үг хэллэгээр орчуулах

Хоёр хэлний хооронд соёлын ялгаа их байвал тухайн өөр үгээр илэрхийлэх

Блам-Кулка, Левинстон нарын судалгаанд дараах жишээг гаргасан байдаг. Na'ara гэдэг үг еврей хэлэнд ихэвчлэн teenager (өсвөр насныхан) гэсэн утгатай байдаг бол, англи хэлнээс еврей хэлэнд орчуулсан орчуулгад girl (охин) гэсэн утга авах тохиолдол байдаг гэжээ. (Mona Baker. ROUTLEDGE Encyclopedia of translation studies, 2001: 288) Судлаач Вандеривэра хавсарсан нийлмэл өгүүлбэрийг хураахдаа цаг заасан үйл үг бүхий гишүүн өгүүлбэрийг хураах аргын нэлээд хэдэн баримт гаргаж ирсэн байна. Энэ нь урт өгүүлбэрийг задлах, гүн утгатай хэлцийг богино яриа болгох арга юм.

Дэлгэрүүлэх ,эх бичвэрт байхгүй үг, өгүүлбэр нэмэх (Explicitation)

Блам-Кулкагийн тодорхойлсноор энэ нь тайлбарлах процессоос үүдэлтэй бөгөөд тэрээр франц хэлнээс англи хэл рүү орчуулсан орчуулгад харьцуулсан анализ хийж жишээ гарган тайлбарласан байна. Мөн түүнчлэн дэлгэрүүлэх зарчим болон уншигчдад ойлгомжтой байх хоёр нь харилцан хамааралтай зүйл юм гэж тодорхойлсон байдаг. Орчуулгын дэлгэрүүлэх зарчим нь соёл хоорондын ялгааг дамжуулахад нэн чухал талаар өгүүлээд жишээ гарган тайлбарласан байдаг. (Mona Baker. ROUTLEDGE Encyclopedia of translation studies, 2001: 289)

Тохируулах, орчуулж буй хэлний онцлогт тохируулан хэлзүйн болон, тэмдэгтийн хувиргал хийх (Normalization)

Эх бичвэрийн өгүүлбэрзүйн байрлал, цэг тэмдэг, таслалын байрлал зэргийг өөрчлөх, зарим тохиолдолд таслал, цэг зэрэг тэмдэгтүүдийг орхиж орчуулахыг хувиргах зарчим гэнэ. Мөн эх бичвэрт гарч байгаа нэр, соёлын зарим ойлголтыг үгийн сангийн түвшинд багасган хурааж, орчуулж буй хэлний хэлцээр орлуулан орчуулсан байдаг. Энэ зарчмаар Судлаач Вандеривэра герман хэлнээс англи хэл рүү орчуулсан орчуулгад нэлээд олон жишээн дээр судалгаа хийж тайлбарласан байдаг билээ.

2.2 орчуулгын нийтлэгийн зарчмын дагуу орчуулгын бүтээлд хийсэн шинжилгээ

Өмнөх ажлын адил “Өвгөн шувуу” өгүүллэгийн англи орчуулгад орчуулгын нийтлэгийн загварын дагуу дүйцэл, нийцлийн шинжилгээ хийж дүгнэлт өгөхийг зорьж ажиллаа. “Өвгөн шувуу” өгүүллэг бол монгол үндэсний соёл, монгол хүний сэтгэлгээний онцлогийг гүнзгий тусгасан бүтээл юм. Өнгөц харахад энгийн нэг хөдөөгийн өглөөний дүрслэл, хорвоогоос буцах өдрөө хүлээсэн өвгөн, хэдэн хөгшдийн хууч дурсамж мэт харагдавч унших тусам тулж ирсэн үйлийн үрийг уужуу тайван угтах монгол хүний сэтгэлгээний мөн чанарыг өгүүлдэг.

Өгүүллэгт орсон үхэлтэй холбоотой, монголын утга зохиолын хэлэнд түгээмэл хэрэглэгддэг дараах хэлц үгийн орчуулгад дээрх зарчмын дагуу шинжилгээ хийж үр дүнг харуулав.

Монгол	Англи	Зарчим
Амьдрах өдөр нь тоотой хүн	his days had been numbered	Хураах /simplification
Үүрд нүдээ аних	closed his eyes and fell into the eternal sleep	Дэлгэрүүлэх/ Explication
Хадан гэртээ харих	to return to the earth	Тохируулах/ normalization
Хойт энгэртээ гарах	to return to the dust	Хураах / Simplification
Өвгөн шувуу буцах цаг болох	the old bird has to return...	Тохируулах/ normalization
Хичнээн сайхан салж болмооргүй ертөнц боловч Гэээгтийн дуулдаг ^{шиг} өвгөн шувуу буцах цаг болжээ.	Such a wonderful world <u>that</u> I reluctantly part, <u>butlike</u> the song that Plait sang, the old bird has to return...	Тохируулах/ normalization
Жам юм хойно	Such is the nature of man’s life	Дэлгэрүүлэх/ Explication
Ямар манай монголын удам тасрахаар биш!	Our Mongolian lineage is never to be cut off, is it?	Тохируулах/ normalization

Principles of translation	Repetition	Method	Equivalence
Simplification	2	Using common level synonym	Equivalent
		Using common level synonym	Not equivalent
Explicitation	2	Explanation	Equivalent
		Explanation	Not Equivalent
Normalization	4	Transformation	Equivalent
		Punctuation	Equivalent

Дүгнэлт

Хаусын дэвшүүлсэн ил болон далд хэв шинжээр орчуулгыг тодорхойлж, тогтоосон үзүүлэлтүүдийн дагуу орчуулгын чанарт шинжилгээ хийснээр: Орчуулгын онолын нэг тулгуур ай болох дүйцэл (эквивалентность) ба нийцэл (адекватность) хэмээх уран зохиолын орчуулгын үнэлгээний нэн чухал үзүүлэлтүүдийг⁸⁹ хэрхэн хангаж байгааг нарийвчлан тодорхойлох боломжтой юм. Өвгөн шувуу өгүүллэгийн орчуулга нь зарим хэсэгтээ өгүүлбэрийн утгад нийцээгүй ч эхийн түвшинд дүйцсэн орчуулга болсон.

Хянган хамрын самсааны мөгөөрс нэвт гэрэлтэн шанааны нь яс арьсаа цоо татах бий гэмээр ёрдойжээ. The cartilage of his high-bridge nose and his cheekbones stuck out as if piercing through his skin.(4/4) “Хянган хамрын самсааны мөгөөрс нэвт гэрэлтэн” гэсэн 2 бүрэлдэхүүнт өгүүлбэрийн өгүүлэхүүний бүлгийг орхиж хамрын ясны мөгөөрс шанааны яс хоёр хоёулаа арьсаа цоо татах шахаж буй мэт орчуулжээ. Эх бичвэрт хамрын мөгөөрс гэрэлтсэн шанааны яс ёрдойсон гэж өгүүлсэн. Хамрын самсаа нь гэрэлтсэн байх нь үхлийн дохио гэж Монголчууд үзэх тохиолдол байдаг. Харин шанааны яс ёрдойх нь үхлийн дохиог шууд илэрхийлдэггүй.

Орчуулгын нийтлэгийн зарчмын дагуу хийсэн шинжилгээгээр Explicitation буюу тайлбарлан дэлгэрүүлэх зарчмаар орчуулсан өгүүлбэрүүд өгүүлбэрийн түвшинд эхтэйгээ нийцэлгүй байх ч эхийн түвшинд дүйцэлтэй тохиолдол олон бүртгэгдсэн. Normalization буюу цэг тэмдэг нэмэх, хасах зарчмаар орчуулсан өгүүлбэр болон утгат хэсгүүд дүйцэл, нийцэл аль нь сайн байсан.

Хичнээн сайхан салж болмооргүй ертөнц боловч Гэээгтийн дуулдаг шувуу буцах цаг болжээ. Such a wonderful world that I reluctantly part, butlike the song that Plait sang, the old bird has to return.

Соёлын ойлголтыг орчуулах тухай судлаачдын дэвшүүлсэн онолын олон тодорхойлолт, зарчмуудыг монгол орчуулгын онцлогт тохируулан орчуулгын

⁸⁹ Магсар. Ц. “Уран зохиолын орчуулгад тавих шаардлага: Дүйцэл ба Нийцэл ойлголтуудын тухай” Орчуулга зүй № 6 хуудас 38

чанарын үнэлгээг бүтээлчээр хийж занших нь сүүлийн үед ихэд олширч байгаа хэл эвдсэн, буруу зөрүү чанар муутай орчуулгын бизнесийг цэгцлэхэд ихээхэн хувь нэмэртэй болно.

Ном зүй:

- Аюурзана.Г Өлзийтөгс.Л (2005), Монголын сонгомол өгүүллэгүүд, УБ., Гүн паблишн
- Ариунаа. Ч, Төгөлмаа. Б, Хосбаяр. С (2015) Орчуулах эрдмийн үндэс, УБ., ХИС сургууль
- Чимэдцэеэ. М (2013), "Үгчлэх утгачлах, идээшүүлэх ондоошуулахын" шүтэлцээ, УБ., "Орчуулга зүй" МУИС, № 02
- Шүгэр. Ц. (1972) "Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг оршив", "Орчуулах эрдэм" № 05
- Элдэв-Очир. Г (2013) "Соёлын утгыг орчуулах арга зам", "Орчуулга зүй" УБ., МУИС, 2013 № 02
- Oyun-Undraa. N, (2009) "The Old bird". Mongol Survey № 22
- Mona Baker. (2001) ROUTLEDGE Encyclopedia of translation studies, New-York, <http://translations.web-3.ru/intro/equivalents/>
<https://translationjournal.net/>
- Juliane House (2014) "Translation Quality Assessment past and present" London and New York
- Claire Kramersch (1998) "Pocket Oxford dictionary" Oxford University Press, <http://ir.lib.cyut.edu.tw:8080>
- Орчуулга зүй № 4, 5, 6